



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/55

Улаан-Уул

Байгаль хамгаалах арга хэмжээний
зардлаас хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө зарцуулах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд суманд тарих модны тарьц суулгац худалдан авахад 16,190,000 (арван зургаан сая нэг зуун ерин мянган) төгрөг, модны тарьц суулгац услах зориулалтаар мотопомп, шланк зэргийг худалдан авахад 3,866,500 (гурван сая найман зуун жаран зургаан мянга таван зуун) төгрөг, 2 дугаар багийн нутаг Хар нүдэнгийн алтны газрын хамгаалалтын албаны зардалд 7,000,000 (долоон сая) төгрөг, нийт 27,056,500 (хорин долоон сая тавин зургаан мянга таван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Уг хөрөнгийг байгаль хамгаалах хөтөлбөр зориулалтын зардлаас зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (С.Хонгорзул), нягтлан бодогч (Ч.Батдорж) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201087